

**“МОНГОЛ УЛС ДАХЬ ЯДУУРЛЫГ БУУРУУЛЖ,
ДУНДАЖ ДАВХАРГЫН ЭГНЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ АРГА ЗАМ”
АЖЛЫН ДААЛГАВАР**

Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 7.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 22 дугаар тогтоол, Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн дүрмийн 3.1, 3.2, 3.3 дагуу дараах зорилгын хүрээнд ажлын даалгаврыг гүйцэтгэнэ.

Судалгааны нэр : “Монгол Улс дахь ядуурлыг бууруулж, дундаж давхаргын эгнээг өргөжүүлэх арга зам”

Зорилго : Монгол Улс дахь ядуурлыг бууруулж, дундаж давхаргын эгнээг өргөжүүлэх арга замыг боловсруулахад чиглэсэн зөвлөмж өгөх.

Хамрах хүрээ :

- **Агуулгын хувьд** : Ядуурлыг бий болгож буй эх үүсвэрийг тодорхойлж, дундаж давхаргыг өргөжүүлэх арга замыг тодорхойлох;
- **Хамрах хүрээ** : Монгол улсын нийгмийн бүх давхаргийн хүрээнд нарийвчлан судлах;
- **Судалгааны түүврийн хувьд** : Монгол Улс дахь ядуурлыг бууруулж, дундаж давхаргын эгнээг өргөжүүлэх арга замыг тодорхойлоход үндэсний хэмжээнд Улаанбаатар хотоос болон аймаг орон нутгийн төлөөлөл болгож багадаа 3000 хүний түүвэртэй хийнэ.

Гүйцэтгэх ажлын төлөвлөгөө :

- судалгааны удирдамж, асуулга боловсруулж, албан ёсны тестийг захиалагч талд танилцуулан батлуулах
- судалгааны мэдээлэл цуглуулж, асуулга судалгааны SPSS болон Excel файл хэлбэрээр форматлагдсан бүрэн өгөгдлийн нэгтгэлийг хүлээлгэж өгөх
- судалгааны үр дүнд боловсруулалт хийж, дэлгэрэнгүй тайлан бичиж, судалгааны үр дүнг танилцуулж, эцсийн байдлаар хүлээлгэж өгөхдөө гэрээ дүгнэсэн акт үйлдэх

Зөвлөхөд тавигдах шаардлага :

Судалгааны ажил гүйцэтгэгчид тавигдах шаардлага:

- ажил гүйцэтгэгч нь судалгааны чиглэлээр ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх,
- сүүлийн 3 жилийн хугацаанд зөвлөх үйлчилгээ явуулахдаа гэрээний үүргээ зөрчөөгүй байх;
- ажлын даалгаврыг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх ур чадвартай, гурваас доошгүй мэргэшсэн судлаачтай байх;
- захиалагчтай нягт хамтран ажиллаж ажлын явц, үр дүнгийн талаар мэдээлэх, шаардлагатай мэдээллийг цаг хугацаанд нь уян хатан, шуурхай гаргаж өгөх;

Судалгааны багийн гишүүдэд тавигдах шаардлага :

- судалгааны багийн ахлагч нь магистр ба түүнээс дээш эрдмийн цолтой байх;
- судалгааны багийн гишүүд нь бакалавр ба түүнээс дээш эрдмийн зэрэг, цолтой байх;
- социологич, улс төр судлаач, статистикч, эдийн засагч мэргэжилтэй байх;
- мэргэжлээрээ гурваас доошгүй жил ажилласан байх;
- эдийн засаг тэр дундаа макро эдийн засгийн талаар дагнасан судалгаа шинжилгээ хийсэн туршлагатай байх;
- идэвх санаачлагатай, бүтээлч, багаар ажиллах чадвартай байх;
- ажлыг богино хугацаанд гүйцэтгэх, ажлын даалгаврыг бүрэн биелүүлэх чадамжтай байх;

---oOo---